

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хөрөнгө оруулалтад түшиглэн дэмжих, Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, хөрөнгө оруулагчид татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг хадгалах, хамгаалах талаар төрийн байгууллагын эрх, үүргийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж

2.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчаас хийж байгаа хөрөнгө оруулалтад хамаарна.

3.2. Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад салбар, үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж болно.

3.3. Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 25.1-д заасны дагуу зөвшөөрөл авсан тохиолдолд хөрөнгө оруулалт хийж болно.

3.4. Хөрөнгө оруулагч нь Компанийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлнэ.

3.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу төрийн байгууллага, албан газарт улсын болон орон нутгийн төсвөөс хийх хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй.

3.6. Олон улсын болон төрийн бус байгууллага, хувийн өмчит аж ахуйн нэгж, иргэнээс арилжааны нөхцөлгүйгээр олгох хандив, буцалтгүй тусламжид энэ хууль хамаарахгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;

4.1.2.“хөрөнгө оруулагч” гэж энэ хуульд заасан хэлбэрээр Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг;

4.1.3.“дотоодын хөрөнгө оруулагч” гэж хөрөнгө оруулалт хийж байгаа Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн болон харьяалалгүй хүн/-ийг;

4.1.4.“гадаадын хөрөнгө оруулагч” гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүн /гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн /-ийг;

4.1.5.“гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа, татвар төлөгч компани, түүний хараат болон охин компани, компанийн нэгдлийг;

4.1.6.“гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар” гэж итгэмжлэлийн үндсэн дээр төлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор гадаадын хуулийн этгээдийн Монгол Улсад байгуулсан хуулийн этгээдийн эрхгүй этгээдийг;

4.1.7.“гадаадын төрийн өмчит хуулийн этгээд” гэж нийт гаргасан хувьцааных нь 50 буюу түүнээс дээш хувийг гадаад улсын төр шууд болон шууд бусаар эзэмшиж байгаа хуулийн этгээдийг;

4.1.8.“хөрөнгө оруулалтын төсөл” гэж ашиг олох зорилгоор энэ хуульд заасан хэлбэрээр хөрөнгө оруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг;

4.1.9.“хөрөнгө оруулалтын дэмжлэг” гэж хөрөнгө оруулагчид төрөөс үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг;

4.1.10.“хөрөнгө оруулалтын гэрээ” гэж энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хөрөнгө оруулагч болон Засгийн газрын хооронд байгуулсан талуудын эрх, үүргийг бий болгож, өөрчилж, дуусгавар болгоход чиглэгдсэн бичгээр үйлдсэн гэрээг;

4.1.11.“татварын хувь, хэмжээг тогтворжуулах” гэж энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд энэ хуулийн 17.1-т заасны дагуу нэмэхгүйгээр хэвээр хадгалах, эсхүл бууруулахыг;

4.1.12.“татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээ” гэж энэ хуулийн 20.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд энэ хуульд заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг тогтворжуулах зорилгоор эрх бүхий байгууллагаас олгох гэрчилгээг /цаашид "тогтворжуулах гэрчилгээ" гэх/;

4.1.13.“тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч” гэж энэ хуульд заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг;

4.1.14.“хөрөнгө оруулагчийн гомдол” гэж төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчаас хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулахаар энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг;

4.1.15.“хөрөнгө оруулалтын маргаан” гэж хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбоотой төрийн байгууллага болон хөрөнгө оруулагч нарын хооронд үүссэн маргааныг.

5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр

5.1.Хөрөнгө оруулалт нь дараах хэлбэртэй байна:

- 5.1.1.хөрөнгө оруулагч дангаараа, эсхүл хамтран аж ахуйн нэгж байгуулах;
- 5.1.2.хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;
- 5.1.3.компанийн нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;
- 5.1.4.төр, хувийн хэвшлийн түншлэл, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;
- 5.1.5.санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх;
- 5.1.6.оюуны өмчийн эрхийг холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт хийх;
- 5.1.7.гадаадын хөрөнгө оруулагчаас өөрийн хөрөнгө оруулсан Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид хувьцаанд хөрвөх зээл олгох;
- 5.1.8.хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАТАЛГАА

6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын нийтлэг баталгаа

6.1.Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах хууль зүйн баталгааг хангана:

6.1.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан аливаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрх тэгш хангаж ажиллана.

6.1.2.төрийн байгууллага, төрийн албан хаагчийн хууль бус үйлдэл, хуульд заагаагүй шаардлага, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, учирсан хохирлыг хуульд заасны дагуу барагдуулна.

6.1.3.төр, түүний эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн оюуны өмчийн эрх, оюуны өмчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасны дагуу хамгаална.

6.1.4.хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу арбитраар шийдвэрлүүлэх эрхийг хангана.

6.2. Төр, түүний эрх бүхий байгууллага хөрөнгө оруулагчийн дараах эдийн засгийн баталгааг хангана:

6.2.1.Төр нь энэ хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох замаар татварын хувь, хэмжээг тогтворжуулах, эсхүл түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын орчныг тогтвортой байлгах баталгаа олгоно.

6.2.2.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар хураан авахыг хориглоно.

6.2.3.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуульд заасан журмын дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно.

6.2.4.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасны дагуу дайчлан авсан хөрөнгийн нөхөн олговрыг тухайн хөрөнгийг

дайчлан авсан үеийн буюу энэ тухай хөрөнгө оруулагчид, эсхүл нийтэд мэдэгдэх үеийн зах зээлийн үнэлгээгээр тооцож, үнийн хамт төлнө.

6.2.5.хөрөнгө оруулагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт татвар төлөх үүргээ бүрэн биелүүлсний үндсэн дээр дор дурдсан өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах эрхтэй:

6.2.5.а.үйл ажиллагаанаас олсон ашиг, ногдол ашиг;

6.2.5.б.энэ хуулийн 5.1-д заасан үйл ажиллагаанаас бий болсон аливаа орлого, төлбөр;

6.2.5.в.гадаад улсаас авсан зээлийн үндсэн төлбөр болон хүү;

6.2.5.г.аж ахуйн нэгжийг татан буулгасны дараа өөрт ногдох хөрөнгө;

6.2.5.д.хуулийн хүрээнд олсон буюу өмчилж байгаа бусад хөрөнгө;

6.2.5.е.энэ хуулийн 6.2.4-т заасан нөхөх олговор.

6.2.6.хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.2.5-т заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон, олон улсад чөлөөтэй хөрвөх гадаад валютад хөрвүүлж, шилжүүлэх эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх

7.1.Хөрөнгө оруулагч дараах нийтлэг эрхтэй:

7.1.1.хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт хийх хэлбэр, хэмжээ, хөрөнгө оруулалт хийх газар, бүс нутаг зэргийг хараат бусаар сонгох, холбогдох шийдвэрийг бие даан дангаар гаргах;

7.1.2.нэг болон түүнээс дээш салбар, төсөл, үйлдвэрлэл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх;

7.1.3.хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох;

7.1.4.Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах;

7.1.5.хөрөнгөө захиран зарцуулах, хууль ёсны орлого, ашгийг хууль тогтоомжид заасны дагуу гадаадад шилжүүлэх, гадаадаас шилжүүлж авах;

7.1.6.хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах буюу удирдахад оролцох, бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх, үүргээ шилжүүлэх;

7.1.7.санхүүжилт, зээл, тусламж, газар, байгалийн баялаг ашиглах хүсэлт гаргах, хүсэлтээ шийдвэрлүүлэх;

7.1.8.төрийн байгууллагын үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзвэл эрх бүхий байгууллагад гомдол гаргах, шүүхэд хандах;

7.1.9.төрийн үйлчилгээг эрх тэгш хүлээн авах;

7.1.10.хуульд заасны дагуу хөрөнгө оруулалттай холбоотой нээлттэй мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах;

7.1.11.хууль тогтоомжид заасан бусад эрх.

8 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн үүрэг

8.1.Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах үндсэн үүргээс гадна дараах нийтлэг үүрэгтэй:

8.1.1.үйлдвэрлэж байгаа бараа, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцэж байх;

8.1.2.нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх;

8.1.3.татварын байгууллага болон мэдээлэл шаардсан бусад төрийн байгууллагад хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;

8.1.4.хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих;

8.1.5.хууль тогтоомжид заасны дагуу ажилтны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх;

8.1.6.ажилтны мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, удирдлага, менежментийн арга барилыг сайжруулахад анхаарч, компанийн удирдлагын сайн засаглалын зарчмыг нэвтрүүлэх;

8.1.7.Монгол Улсын үндэсний өв уламжлал, ёс заншлыг хүндэтгэх;

8.1.8.хөрөнгө оруулалтаа бодитоор хийсэн байх;

8.1.9.байгаль орчин, нийгэм, засаглалын сайн туршлага, арга барилыг нэвтрүүлэх;

8.1.10.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

9 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

9.1.Засгийн газар хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх.

9.1.2.энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрх олгох;

9.1.3.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр шийдвэр гаргах.

9.2.Засгийн газар энэ хуулийн 24.10, 28.6-д заасан журмыг тус тус баталж, мөрдүүлнэ.

10 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих;

10.1.2.хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

10.1.3.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл өгөх;

10.1.4.тогтворжуулах гэрчилгээ олгох, хэрэгжилтэд хяналт тавих

10.1.5.гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох;

10.1.6.энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тайлан, мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах;

10.1.7.энэ хуулийн 9.2-т заасан журмыг боловсруулах;

10.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.

10.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 11.1.7, 27.6-д заасантай холбоотой журмыг баталж мөрдүүлнэ.

11 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

11.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хөрөнгө оруулалтыг татах цогц үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх;

11.1.2.хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах;

11.1.3.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

11.1.4.хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;

11.1.5.хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;

11.1.6.хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төслийг хөгжүүлэх, бэлэн байдлыг хангах, хөрөнгө оруулалт татахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, төслийн мэдээллийн сан бүрдүүлэх;

11.1.7.хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр төв банк, төсөв, санхүү, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, гадаадын иргэн, харьяат, газар, чөлөөт бүс болон шүүхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас хөрөнгө оруулалттай холбоотой статистик мэдээллийг улирал, хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгдсэн статистик мэдээллийг гаргах;

11.1.8.хуульд заасан бусад.

12 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллагын чиг үүрэг

12.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө.

12.2.Холбогдох хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд ижил төрлийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлнэ.

12.3.Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжид хийх төрийн хяналт шалгалтын тоо жилд 2-оос ихгүй байна.

13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

13.1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасныг баримтлан харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.

13.2.Харьяалах нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, тогтворжуулах гэрчилгээ олгосон хуулийн этгээдэд хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтыг дэмжих талаар Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрх

14.1.Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин, дотоод зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төсөл, хөтөлбөрийг сурталчлах чиглэлээр ажиллана.

14.2.Дипломат төлөөлөгчийн газар энэ хуулийн 14.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэх журмыг хөрөнгө оруулалтын болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ

15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын дэмжлэг

15.1.Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр хөрөнгө оруулалтын татварын дэмжлэг үзүүлнэ:

15.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөх үүргийг 3 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах;

15.1.2.тогтворжуулах гэрчилгээ авсан, эсхүл хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн татварын хувь, хэмжээг тогтворжуулах;

15.1.3.албан татвар ногдох орлогоос хасагдах элэгдэл хорогдлын хэмжээг түргэвчилсэн аргаар тооцох;

15.1.4.ажилтны мэргэжлийн боловсрол, сургалтын зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцох;

15.2.Хөрөнгө оруулагчид үзүүлэх энэ хуулийн 15.1-т заасан татварын дэмжлэгийг татварын тухай хууль тогтоомжоор зохицуулна.

16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэг

16.1.Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэгийг үзүүлж болно:

16.1.1.газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;

16.1.2.чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэх;

16.1.3.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх;

16.1.4.хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэдээлэл, зөвлөгөө, шаардлагатай зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх;

16.1.5.экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

16.1.6.Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг олгох;

16.1.7.хуульд заасан бусад дэмжлэг.

16.2.Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг энэ хууль, Газрын тухай, Чөлөөт бүсийн тухай, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Инновацийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ ТОГТВОРЖУУЛАХ

17 дугаар зүйл.Татварын хувь, хэмжээг тогтворжуулах

17.1.Энэ хуулийн 17.5-д заасан этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох замаар хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг тогтворжуулна.

17.2.Тогтворжуулах гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд уг гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хувь, хэмжээг тогтворжуулна.

17.3.Татварын хувь, хэмжээг тогтворжуулах асуудлыг зөвхөн энэ хууль болон энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулна.

17.4.Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 18.1-д заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг бууруулах өөрчлөлт орсон тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлтөд хамаарахгүй.

17.5.Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэрээс нь хамааран тогтворжуулах гэрчилгээг дараах этгээдэд олгоно:

17.5.1.хөрөнгө оруулалтын төслийг нэг хуулийн этгээд дангаар хэрэгжүүлэх бол тогтворжуулах гэрчилгээг тухайн хуулийн этгээдэд;

17.5.2.хөрөнгө оруулалтын төслийг харилцан хамаарал бүхий хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хэрэгжүүлэх бол тэдгээрийн толгой компанид.

17.6.Тамхи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах үйл ажиллагаанд татварын хувь, хэмжээг тогтворжуулахгүй.

18 дугаар зүйл.Тогтворжуулах татварын төрөл

18.1.Тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна:

18.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

18.1.2.гаалийн албан татвар;

18.1.3.нэмэгдсэн өртгийн албан татвар;

18.1.4.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.

18.2.Ашигт малтмалын үндсэн ордыг ашиглах зорилгоор олгосон энэ хуулийн 18.1.4-т заасан татварын тогтворжуулалтад үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хамаарахгүй.

19 дүгээр зүйл.Тогтворжуулах гэрчилгээ

19.1.Тогтворжуулах гэрчилгээний загварыг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бата.2лна.

19.2.Тогтворжуулах гэрчилгээнд дараах мэдээллийг тусгана:

19.2.1.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг;

19.2.2.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар;

19.2.3.энэ хуулийн 17.5.2-т заасан хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар;

19.2.4.хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн нэр;

19.2.5.тогтворжуулах гэрчилгээ олгосон он, сар, өдөр, хүчинтэй байх хугацаа;

19.2.6.энэ хуулийн 18.1-д заасан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээ.

19.3.Тогтворжуулах гэрчилгээг бусдад худалдах, барьцаалах, бэлэглэхийг хориглоно.

19.4.Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдахад тогтворжуулах гэрчилгээ нь шинээр бий болсон буюу эрх залгамжлан авсан хуулийн этгээдэд дараах шаардлагыг хангасан тохиолдолд шилжинэ:

19.4.1.хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;

19.4.2.хөрөнгө оруулалтын төсөл нь энэ хуулийн 20.1-д заасан шалгуурыг хангаж байх.

20 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуур, хугацаа

20.1.Хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл нь доор дурдсан шалгуурыг бүрэн хангасан тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ олгоно:

20.1.1.бизнес төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэлд заасан хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь энэ хуулийн 20.2, 20.3-т заасан хэмжээнд хүрэх;

20.1.2.хуульд заасан бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэсэн байх

20.1.3.тогтвортой ажлын байр бий болгох;

20.1.4.дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх.

20.2.Тогтворжуулах гэрчилгээг доор дурдсан салбарт дараах хугацаагаар олгоно:

20.2.1.уул уурхайн олборлолт, хүнд үйлдвэр, дэд бүтцийн салбарт:

Хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөгөөр/	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/					Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа /жилээр/
	Улаанбаатарын бүс	Төвийн бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Баруун бүс	
30-100 хүртэл	5	/Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/	/Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/	/Дорнод, Сүхбаатар, Хэнтий/	/Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд/	2

100-300 хүртэл	8	9	9	10	11	3
300-500 хүртэл	10	11	11	12	13	4
500-аас дээш	15	16	16	17	18	5

20.2.2.энэ хуулийн 20.2.1-д зааснаас бусад салбарт:

Хөрөнгө оруулалтын хэмжээ/тэрбум төгрөгөөр/					Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/	Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа /жилээр/
Улаанбаатарын бүс	Төвийн бүс /Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв/	Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл/	Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий/	Баруун бүс /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан Увс,Ховд/		
10-30 хүртэл	10-15 хүртэл	10-12 хүртэл	10-12 хүртэл	2-8 хүртэл	5	2
30-100 хүртэл	15 -50 хүртэл	12-40 хүртэл	12-30 хүртэл	8-25 хүртэл	8	3
100-200 хүртэл	50 -100 хүртэл	40-80 хүртэл	30-60 хүртэл	25-50 хүртэл	10	4
200-аас дээш	100-аас дээш	80-аас дээш	60-аас дээш	50-аас дээш	15	5

20.3.Дараах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээний хугацааг энэ хуулийн 20.2-т заасан хугацааг 1.5 дахин уртасган тооцож олгоно:

20.3.1.улс орны нийгэм, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжилд онцгой ач холбогдол бүхий импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх, техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан өдрийн Төв банкны албан ханшаар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх тооцоотой, бүтээн байгуулалтын ажилд гурваас дээш жил шаардагдах төслийг байршил, салбар харгалзахгүйгээр;

20.3.2.энэ хуулийн 20.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээд нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэл эрхлэн, үндсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж байгаа.

20.4.Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацааг тогтворжуулах гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн тооцно.

20.5.Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь энэ хуулийн 20.2-т заасан хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацааг сунгах хүсэлтээ хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл энэ хугацааг 2 хүртэл жилээр сунгаж болно.

21 дүгээр зүйл.Тогтворжуулах гэрчилгээ авах тухай хүсэлт гаргах

21.1.Энэ хуулийн 20.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлтээ хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

21.2.Тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлтэд доор дурдсан бичиг баримтыг хавсаргана:

21.2.1.энэ хуулийн 20.1-д заасан шалгуурыг хангасан тухай хүсэлт гаргагч хуулийн этгээдийн мэдэгдэл;

21.2.2.хүсэлт гаргагч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ, хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн баримт бичгийн хуулбар;

21.2.3.дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж байгаа талаарх танилцуулга;

21.2.4.хуульд заасан бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ;

22 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох

22.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлт, холбогдох бичиг баримтыг цахимаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан шалгуурыг үндэслэн тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ.

22.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтворжуулах гэрчилгээг олгохоор шийдвэрлэсэн бол тогтворжуулах гэрчилгээнд холбогдох бичилтийг хийж, гэрчилгээг төсөл хэрэгжүүлэгч Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.

22.3.Хөрөнгө оруулалтын төсөл нь энэ хуулийн 20.1-д заасан шалгуурыг хангаагүй буюу бичиг баримтын бүрдэл дутуу тохиолдолд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох үндэслэл бүхий гэрчилгээ олгохоос татгалзсан хариуг энэ хуулийн 22.1-д заасан хугацаанд цахимаар хөрөнгө оруулагчид хүргүүлнэ.

22.4.Энэ хуулийн 19.2-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтворжуулах гэрчилгээнд өөрчлөлт оруулна.

23 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох

23.1.Тогтворжуулах гэрчилгээг доор дурдсан үндэслэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хүчингүй болгоно:

23.1.1.тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссан;

23.1.2.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд хүсэлт гаргасан, эсхүл татан буугдсан;

23.1.3.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд Монгол Улсад оруулсан хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс бүрэн татаж, шилжүүлсэн;

23.1.4.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь хууль бус бичиг баримт бүрдүүлэн тогтворжуулах гэрчилгээг авсан болох нь тогтоогдсон;

23.1.5.эрх залгамжлагч нь энэ хуулийн 19.4-т заасан шаардлагыг хангаагүй;

23.1.6.энэ хуулийн 19.3-т заасныг зөрчсөн;

23.1.7.гадаадын төрийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 25.1-д заасан зөвшөөрөл аваагүй болох нь тогтоогдсон;

23.1.8.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь энэ хуулийн 20.2-т заасан хугацаанд хөрөнгө оруулалтаа хийгээгүй;

23.1.9.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.

23.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 23.1-д заасан үндэслэлээр тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэрээ ажлын таван өдөрт багтаан тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдэд болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ

24.1.Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан хэмжээний хөрөнгө оруулалт хийх тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь өөрөө хүсэлт гаргавал түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.

24.3.Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

24.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг хянан үзээд холбогдох хууль тогтоомжид заасан татгалзах үндэслэл тогтоогдоогүй бол хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээнд урих талаар Засгийн газарт танилцуулж, зөвшөөрөл авна.

24.5.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон тухайн салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний хамтарсан тушаалаар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээ хийх ажлын хэсгийг байгуулж, хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх ажиллагааг эхлүүлнэ.

24.6.Хэлэлцээний үр дүнд харилцан тохиролцсон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

24.7.Засгийн газар тухайн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг дэмжсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар эрх олгосны дагуу хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна.

24.8.Хөрөнгө оруулалтын гэрээг хөрөнгө оруулалтын зорилго, үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэр, хөрөнгө оруулах хугацаа, үе шат зэргийг харгалзан энэ хуулийн 20.2, 20.3-т зааснаас доошгүй хугацаагаар байгуулж болно.

24.9.Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх нөхцөлийг заавал тусгасан байна.

24.10.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, хөрөнгө оруулалтын гэрээний загварыг Засгийн газар батална.

24.11.Гадаадын төрийн төрийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 25.1-д заасны дагуу зөвшөөрөл авсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргаж болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ГАДААДЫН ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ

25 дугаар зүйл.Гадаадын төрийн өмчит хуулийн этгээд хөрөнгө оруулалт хийх

25.1.Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна:

25.1.1.уул уурхай;

25.1.2.банк, санхүү;

25.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо.

26 дугаар зүйл.Зөвшөөрөл хүсэх, хүсэлтийг шийдвэрлэх

26.1.Энэ хуулийн 25.1-д заасан хуулийн этгээд нь зөвшөөрөл хүсэх тухай хүсэлтээ шууд болон Монгол Улс дахь төлөөлөгчийн газар болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

26.1.1.зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн эрх бүхий бүртгэлийн байгууллагаас олгосон хуулийн этгээдийн нотариатаар гэрчлүүлсэн гэрчилгээний хуулбар;

26.1.2.зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, энэ хуулийн 26.1-д заасан этгээдийн гүйцэтгэх удирдлагын талаарх бүртгэлийн байгууллагын сүүлийн хоёр жилийн лавлагаа;

26.1.3.гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн монголын талын аж ахуйн нэгжтэй урьдчилан тохиролцсон хэлцэл, түүний төрөл, нөхцөл, хэлцэлд оролцогч талууд, худалдах хувьцааны тоо болон хувь эзэмшлийн хэмжээ, гэрээний үнэ болон хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн удирдлагад өөрчлөлт оруулахаар тохиролцсон бол энэ талаарх мэдээлэл;

26.1.4.гадаадын төрийн өмчит хуулийн этгээдийн болон хэлцэлд оролцогч монголын талын аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга;

26.1.5.зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бизнес төсөл.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан бичиг баримт нь монгол хэлээр байна.

26.3.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг нягтлах явцад зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдээс энэ хуулийн 26.1-д зааснаас бусад шаардлагатай бичиг баримтыг шаардаж болно.

26.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 26.1-д заасан шаардлага хангасан хүсэлтийг хүлээн авч, дараах нөхцөл байдал үүсэх эсэхийг нягтална:

26.4.1.хөрөнгө оруулагчийн аливаа үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын шинж чанар нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд харшилсан эсэх;

26.4.2.хүсэлт гаргагч нь Монгол Улсын хууль тогтоомж, бизнесийн тогтсон хэм хэмжээг сахин биелүүлэх нөхцөл, боломжийг хангасан эсэх;

26.4.3.хөрөнгө оруулалт нь тухайн салбар дахь өрсөлдөөнийг хязгаарлах, давамгайл байдал тогтоох шинжийг агуулсан эсэх;

26.4.4.хөрөнгө оруулалт нь Монгол Улсын төсвийн орлого, бусад бодлого, үйл ажиллагаанд ноцтой нөлөөлөл үзүүлэх эсэх.

26.5.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 26.4-т заасан нөхцөл байдал үүссэн эсэхийг нягтлахдаа холбогдох байгууллагаас санал, дүгнэлт авч болно. Энэ тохиолдолд тухайн байгууллага нь асуудлыг 30 хоногийн дотор судлан үзэж, санал, дүгнэлтээ ирүүлэх бөгөөд уг хугацаанд ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүйд тооцно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

27 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавих

27.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажиллана.

27.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

27.3.Энэ хуулийн 27.1-д заасан хяналтыг холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

27.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах талаар зөвлөмж, чиглэл өгч болно.

27.5.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 27.4-д заасан зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж, энэ талаарх тайлан, мэдээллийг заасан хугацаанд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

27.6.Энэ хуулийн 27.1-д заасан үйл ажиллагааг зохицуулах журмыг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ГОМДЛЫГ УРЬДЧИЛАН

ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

28 дугаар зүйл.Хөрөнгө оруулагч гомдол гаргах, гомдлыг шийдвэрлэх

28.1.Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдлоо хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар гаргана.

28.2.Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг хүлээн авч, судлан гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний талаар саналаа хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

28.3.Энэ хуулийн 28.1-д заасан гомдлыг шийдвэрлэх хүрээнд холбогдох байгууллагаас мэдээлэл, тайлбар авах, тусгай мэдлэг шаардсан тохиолдолд хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр шинжээч томилж, дүгнэлт гаргуулж болно.

28.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

28.5.Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.4-т заасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.

28.6.Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.

АРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МАРГААН

29 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын маргаан

29.1.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

29.2.Талууд хэлэлцээний замаар маргааныг шийдвэрлүүлэхээр бичгээр мэдэгдэл хүргүүлснээс хойш 3 сарын дотор шийдвэрлэж чадаагүй тохиолдолд дараах олон улсын гэрээний дагуу арбитра хандах эрхтэй:

29.2.1.гадаадын хөрөнгө оруулагч нь 1965 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Улс болон гадаад улсын иргэд хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцид нэгдсэн улсын харьяалалтай тохиолдолд Хөрөнгө оруулалттай холбогдсон маргааныг шийдвэрлэх олон улсын төв (ХОМШОУТ), эсхүл;

29.2.2.НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Олон улсын худалдааны эрх зүйн НҮБ-ын Комиссын арбитрын дүрэм (ЮНСИТРАЛ)-ийн дагуу арбитрын шүүх буюу олон улсын түр арбитр.

29.3.Гадаадын хөрөнгө оруулагчид болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу Монгол Улсын арбитр, түүнчлэн гадаадын арбитра хандан шийдвэрлүүлж болно. Хэрэв ийм арбитрын хэлэлцээргүй бол маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

30 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

30.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

30.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

31.1.Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ